

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Эрдэнэт хивс” хувьцаат компанийн нийтэд санал болгон гаргасан 3 105 573 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ)-д, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Р.Содхүү)-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хагаламжийн төв” ХХК (Т.Гандулам)-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж байгаатай холбогдуулан хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Эрдэнэт хивс” ХК /Ө.Мянганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэж тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ